



САНГИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А215.

Улаанбаатар хот

Ёс зүйн хороо байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам" –ын 2.2 – т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн яамны төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий ёс зүйн хороог яамны хамт олны дунд явуулсан санал асуулгын дүнгээр хамгийн олон санал авсан дараах албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ёс зүйн хорооны дарга:

С.Мөнгөнцэцэг

Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга

Гийшүүд:

П.Билгүүн

Хууль, эрх зүйн газрын дарга

Н.Нарангэрэл

Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга

Ц.Зоригтбат

Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга

Б.Сүх-Очир

Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга

Б.Болормаа

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Д.Дэгд

Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Хоёр. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон

Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмыг баримтлан ажиллахыг ёс зүйн хороо /С.Мөнгөнцэцэг/-нд даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Б.НЯМАА